

АРХАНГАЙ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 01

Эрдэнэбулган сум

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 зорилт, 50 арга хэмжээг тусган боловсруулж Цаг уур, орчны шинжилгээний газрын даргаар батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа.

Энэхүү төлөвлөгөөний жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын “Аргачлал батлах тухай” 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан загварын дагуу гаргаж Цаг уур, орчны шинжилгээний газарт хүргүүлсэн.

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР


Манай төв нь 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 3 хэлтэс, цаг уурын 4 өртөө, 13 харуул, ус судлалын 10 харуул, байгаль орчны шинжилгээний лаборатори, 1 цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны Цэцэрлэг бороо-1 экспедиц, нийт 70 орон тоотой ажиллаж байгаад 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн “Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” А/162 дугаар тушаалаар нэгжийн зохион байгуулалтгүй болж цаг уурын 4 өртөө, 13 харуул, ус судлалын 10 харуул, байгаль орчны шинжилгээний лаборатори, 1 цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны Цэцэрлэг бороо-1 экспедиц, нийт 63 орон тоотойгоор ус цаг уур, орчны шинжилгээний хөтөлбөрт ажлыг гүйцэтгэлээ.

1.1 Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд

Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, Засгийн газар болон удирдах дээд байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг заасан хугацаанд зохион байгууллаа.

Байгууллагын дарга, 3 хэлтсийн дарга Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ээ АТГ-ын meduuleg.iaac.mn сайтад цахим хэлбэрээр хуулийн хугацаанд мэдүүлж баталгаажуулан, баталгааны маягтыг Цаг уур, орчны шинжилгээний газар (ЦУОШГ)-ын эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн.

Ахмадын зөвлөл, Өмч хамгаалах байнгын зөвлөл, Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл, байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, Мэргэшлийн зэргийн салбар ажлын хэсэг зэрэг байнгын ажлын хэсэг, зөвлөлүүд үйл ажиллагаагаа хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн байна.




Зураг 1. Ёс зүйн дэд хороо, 2025 оны төлөвлөгөө хэлэлцэх, хамт олны аялал эв нэгдгэлийг бэхжүүлэх аялал, зугаалга Өгий нуур

Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл нь 2025 оны төлөвлөгөөгөө 01 сарын 15-нд батлуулж мөрдөж ажилласан.

11 дүгээр сарын 30-ны байдлаар нийт 5 удаа хуралдаж байгууллагын өмчийн талаарх асуудлыг шийдвэрлэж санал дүгнэлтээ гаргасан байна. 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаар 1 хүнд ногдох ажлын байрны талбай 6м^2 , эзэлхүүн нь 20м^3 -ээс багагүй байх зарчмыг баримтлан байгууллагын сул өрөө тасалгааг ашиглан албан хаагчдыг хуваарилж, албан хаагчдын сургалт, мэдээлэл хийх өрөөг гаргаж тохижууллаа.




Зураг.2. Сургалт, мэдээллийн өрөө



Зураг.3. Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн зааварчилгааны өгч, танхимын холбогдох сургалтыг зохион байгуулж буй (2025.03.21)

Байгууллагын даргын 2025 оны А/08 дугаар тушаалаар “Байгууллагын дотоод хяналт шалгалтын нэгж”-ийг шинээр байгуулсан.

Тус дотоод хяналт шалгалтын нэгжээс ахлах нягтлан бодогч Г.Гэрэлмаа, нярав Ч.Оюунтуяа (санхүү), Хүний нөөц, архив, бичиг хэргийн эрхлэгч Д.Гантуул, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод ажил хариуцсан ажилтан Б.Гантулга нарын ажил үүргийг хамруулан 2025 оны 5 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд дотоод хяналт шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу гүйцэтгэсэн байна.



Зураг 4. Дотоод хяналт шалгалтын хүрээнд хийгдсэн ажлын мэдээллээс...

Албан тушаалын тодорхойлолтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шинэчлэн боловсруулж баталлаа.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан аргачлал, загварын дагуу байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн тайланг нэгтгэж, ЦУОШГ-т хугацаанд нь хүргүүлж үнэлүүлсэн.

Байгууллагын хэлтэс, төрийн албан хаагчдын 2025 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалаар баталсан аргачлал, загварын дагуу баталж, эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх ажлыг зохион байгуулж ажлын хэсгийн санал, дүгнэлтийг төвийн даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэн үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэсэн.

Ур чадвар олгох журмыг байгууллагын онцлогт нийцүүлэн боловсруулж баталсан бөгөөд улирал бүр ажлын хэсэг байгуулан албан хаагчдын ур чадварыг үнэлүүлж, ур чадварын нэмэгдлийг олгох асуудлыг шийдвэрлэсэн.

Байгууллагын албан хаагчдад нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг Засгийн газрын “Журам батлах тухай” 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан холбогдох журмын дагуу бүрэн олгосон.

Бодлогын баримт бичиг (хөтөлбөр, төлөвлөгөө), Засгийн газар, Улс, аймгийн Онцгой комисс, удирдах дээд байгууллага, албан тушаалтны шийдвэрийн хэрэгжилтийг хангаж тайлан, мэдээ, судалгааг хугацаанд нь гаргаж хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.

11 дүгээр сарын 30-ны байдлаар байгууллагад иргэдээс тус байгууллага, албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдол ирээгүй.

Хариутай 97 баримт бичгийг хяналтын хугацаанд бүрэн шийдвэрлэсэн. Дотооддоо шийдвэрлүүлэх 57 хүсэлтийн 55 хүсэлтийг шийдвэрлэсэн, 2 хүсэлтийг шийдвэрлэх хугацаа болоогүй байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 1,2,3 дугаар улирал болон 10 дугаар сарын 24-ны байдлаарх өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээг шинээр батлагдсан маягтаар гаргаж холбогдох цахим шуудангаар илгээсэн байна.

Албан хэрэг хөтлөлтийг “Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем-ERP”-гээр явуулж, албан бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулан төрийн байгууллагуудтай баримт бичгүүдийг түргэн шуурхай солилцож хэвшсэн.

Уг системийн албан бичиг, үүрэг даалгавар, цагийн бүртгэл, албаны цахим шуудан зэрэг цэсүүдийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хөдөлмөрийн болон технологийн сахилгын зөрчил гаргасан 1 албан хаагчид нийт ажилтанд нь зарлах хэлбэрээр нээлттэй сануулах хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан.

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 оны 22 нэр төрлийн 3136 хуудас баримтыг байгууллагын архивт хүлээн авсан.

Архивын улсын үзлэг болон бүтэц орон тоо шинэчлэгдэж албан тушаал өөрчлөгдсөнтэй холбоотойгоор шинжилгээний төрөлжсөн архивын баримтыг нэр төрлөөр ангилан төрөлжүүлж, тавиурт байрлуулж, байгууллагын архивын баримтад тооллого хийх ажлын хэсгийг байгуулж, тооллогыг холбогдох хууль тогтоомжийн дагуу 10 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Аймгийн Архивын хэлтсээс архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн урьдчилсан үзлэгт хамрагдаж албан хэрэг хөтлөлт 735.6, төрийн ажлын зохион байгуулалт 65, байгууллагын архивын үйл ажиллагаа 668 оноогоор тус тус үнэлэгдсэн байна.

1.2 Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар

Эрдэнэмандал, Төвшрүүлэх цаг уурын өртөөнд улсын төсвийн 480.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2 ширхэг пассив барилга баригдаж 2025 оны 11 дүгээр сарын 18-19-нд ашиглалтад орсон.

Хөмрөг үүсгэгч архивын өрөөг стандартад нийцүүлэн хаалгыг төмөрлөн, дотор өнгө үзэмжийг сайжруулж, галын аюулгүй байдлыг ханган галын хор, элс, хүрз зэргийг өрөөнд байршуулж, цонхыг битүүмжлэх ажлыг зохион байгуулсан.

Мөн төвийн конторын барилгын гадна өнгийг сэргээж, байгууллагын гадна хаягийг стандартын дагуу болгон шинэчилсэн.

Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөл өрөөний хуваарилалтыг ажлын чиг үүргийн дагуу хуваарилж, сургалт, мэдээллийн өрөөнтэй болголоо.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн дагуу байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгөх ажлыг хэвшүүлсэн.

Нийт албан хаагчдын 2025 оны ажлын жилийн ээлжийн амралтын хуваарийг төвийн албан хаагчдаас саналыг харьяалах хэлтсийн дарга нар, технологич инженерүүд нэгтгэн авч батлуулан, 2025 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар нийт албан хаагчид хуваарийн дагуу “Мэдэгдэх хуудас”-аар 2025 оны ажлын жилийн ээлжийн амралтаа эдлээд байна.

Хангай сумын хөдөө аж ахуйн цаг уурын харуулын техникч Ч.Энхжаргал, Булган сумын хөдөө аж ахуйн цаг уурын харуулын техникч Н.Наранцэцэг, Чулуут сумын цаг уурын харуулын техникч З.Мөнхзул нарын ээлжийн амралтын хугацаанд орлон ажиллах хүнгүй учраас 1 сарын мэдээг хааж амраан, биеэр эдэлж чадаагүй ээлжийн амралтын хоногийн

цалинг Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу 1.5 дахин нэмэгдүүлж, нийт 426.2 мянган төгрөг олгосон.

2025 оны 11 дүгээр сарын гүйцэтгэлээр 68 албан хаагчид алба хаасан хугацааны нэмэгдэл 118,507.9 мянган төгрөг, 16 албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл 22,289.2 мянган төгрөг, 44 албан хаагчид ур чадварын нэмэгдэл 37,977.4 мянган төгрөг, 47 албан хаагчид илүү цаг, нийтээр амрах баяр ёслолын өдөр ажилласан цагийн нэмэгдэл, шөнийн цагийн нэмэгдэлд нийт 106,060.1 мянган төгрөг, 68 албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл 283,289.8 мянган төгрөг, 2025 оны эхний хагас жилийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэж хэвийн болон маш сайн үнэлгээгээр үнэлэгдсэн 62 албан хаагчдад 56,673.9 мянган төгрөгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцож тус тус олгосон байна.

Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын дагуу төвийн албан хаагчдад хоол унааны зардлыг өдрийн 20,000 төгрөгөөр, сумдын албан хаагчдад хоолны зардлыг өдрийн 10,000 төгрөгөөр тус тус тооцон олгож байгаа бөгөөд 11 дүгээр сарын гүйцэтгэлээр нийт 154,877.1 мянган төгрөг, мөн БОШЛ-ийн 3 албан хаагчид хөдөлмөрийн хортой нөхцөлийн нэмэгдэл 3,908.0 мянган төгрөг олгосон байна.

2025 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар албан томилолтоор ажилласан 11 албан хаагчид 1,469.4 мянган төгрөгний албан томилолтын зардлын олгосон.

2 албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахаар хүсэлтээ өгч 67,369.3 мянган төгрөгийн тэтгэмж батлагдсан. 11 дүгээр сарын байдлаар Сангийн яамнаас санхүүжилтыг олгоогүй хүлээгдэж байна.

Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу нийт 15 албан хаагчид 3-5 ажлын өдрийн цалинтай чөлөө олгосон.

1.3 Хүний нөөцийн сургалт, чадавхжуулах талаар

Нийт албан хаагчдын 73 хувь нь эмэгтэй, 27 хувь нь эрэгтэй байгаа бөгөөд боловсролын хувьд суурь болон бүрэн дунд боловсролтой 19, техник мэргэжлийн 7, диплом бакалавр 41, магистр 6 албан хаагч тус тус байна.

Байгууллагын албан хаагчдыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ), ЦУОШГ, Төрийн албаны зөвлөл, аймгийн Засаг даргын Тамгын газар (АЗДТГ), бусад төсөл, хөтөлбөр, төрийн бус байгууллагаас зохион байгуулсан цахим болон танхимын 22 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт тус тус хамруулсан.

Ажлын байран дахь сургалт-зорилтот 5 (хүрсэн түвшин 8), мэргэшүүлэх сургалт-зорилтот 4 (хүрсэн түвшин 8), туршлага солилцох арга хэмжээ-зорилтот 2 (хүрсэн түвшин 21), бусад-зорилтот Тухай бүр (хүрсэн түвшин 10), нийт 47 удаагийн сургалт, семинар, зөвлөгөөнд оролцсон байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан сургалтуудад тухай бүр нь хамаарах албан хаагчдыг оролцуулсан.



Зураг 5. 2025 оны 06 дугаар сарын 12, Төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалт

Эдгээрээс онцлох салбарын сургалтуудыг дурьдвал:

Дотоод сургалт:

- ✓ Архангай аймгийн Засаг даргын тамгын газар Архивчдын хөгжил сургалт арга зүйн төвтөй хамтран зохион байгуулсан танхимын сургалтад 4 албан хаагч, Архивын ерөнхий газраас зохион байгуулсан албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, MNS 5140:2021 баримт бичгийн стандартын цахим сургалтад 11 албан хаагчийг тус тус хамруулж, гэрчилгээ авсан
- ✓ Цэцэрлэг цаг уурын өртөө, Хашаат, Цэцэрлэг цаг уурын харуулуудад тус бүр 1, Эрдэнэмандал өртөө 4, нийт 7 иргэнийг ажлын 10 хоногийн хугацаанд мэргэжлийн чиглэл олгох сургалтад тус тус бэлтгэн, сургаж дадлагажуулсан.
- ✓ Нийт албан хаагчид Үндэсний монгол бичгийн мэдлэг дээшлүүлэх анхан шатны сургалт (5 цаг, 31 минут)-ыг цахимаар судалж гэрчилгээ авсан.
- ✓ БОХЗТЛ-оос зохион байгуулсан Шалгалт тохируулгийн ажилтны үнэмлэх сунгах 5 хоногийн сургалтад Цаг уур, орчны технологий хэлтсийн дарга Д.Их-Оюун 04 дүгээр сарын 27-30-ны өдрүүдэд, Пиротехникийн нөхцөлд тэсрэх материалтай харьцах эрх сунгах сургалтад технологич инженер Ш.Отгонсамбуу, техникч-жолооч Э.Бадрах нар 04 дүгээр сарын 07-08, 14-15-ны өдрүүдэд тус тус оролцлоо.
- ✓ Урьдчилан мэдээлэхийн 3 инженер 10 дугаар сарын 5-10-ны хооронд мэргэшүүлэх сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан.
- ✓ 01 дүгээр сарын 02, 05 дугаар сарын 01 нд БОУАӨЯ-аас цахимаар зохион байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, санхүү, аудит, хүний нөөцийн чиглэлийн сургалтад 4 албан хаагч хамрагдсан.
- ✓ 05 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” Хангайн бүсийн зөвлөгөөнд 1 албан хаагч хамрагдсан.
- ✓ ТАЗ-өөс зохион байгуулж байгаа 7:4:10 сургалт, мэдээллийн 4 удаагийн сургалтад албан хаагчдыг хамрууллаа.
- ✓ Урьдчилан мэдээлэхийн инженер Б.Мөнхбулган 06 дугаар сарын 02-ны өдрөөс 24-ний өдрийг хүртэл нисэхийн цаг уурын төвийн сургалтад хамрагдаж, “Нислэгт цаг агаарын урьдчилсан мэдээгээр үйлчлэх” эрх авсан.
- ✓ Байгаль орчны шинжилгээний лабораторийн технологич инженер 06 дугаар сарын 30, 10 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд, мөн инженерийн хамтаар 11 дүгээр сарын 24-25-ны өдрүүдэд агаарын чанарыг хянах автомат суурин багажид гарсан гэмтэл оношлох, шалгах, засвар үйлчилгээг хийхэд чадавхыг сайжруулах, агаарын чанарын дүн мэдээг боловсруулах (Agaar.mn, MAMIS.mn) сургалтад хамрагдсан.



1. Тохиргоо үйлчилгээ хийх ерөнхий сургалт 04 дүгээр сарын 15-ны өдөр хийсэн.



2. Онол болон практик сургалт 06 дугаар сарын 30-нд Байгаль орчин судалгаа мэдээллийн төвд хийгдсэн.



3. Агаарын чанарын удирлагын системн сургалт хийсэн

Зураг 6. Агаарын чанарыг хэмжих автомат станцын сургалт

- ✓ Цаг уур, орчны шинжилгээний газраас зохион байгуулсан Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмыг танилцуулах цахим сургалтад нийт 12 албан хаагч оролцлоо.
- ✓ Дэлхийн ус, цаг уурчдын баярын өдрийг тохиолдуулан Архангай аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын төгсөх 12 дугаар ангийн сурагчдын дунд “Мэргэжил бүхэн сайхан” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулж, ажлын онцлог байдалтай танилцуулж, сонирхсон сурагчдад үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа багаж, техник, тоног төхөөрөмжүүдийг танилцууллаа.
- ✓ Цаг уурын мэргэжил сайхан” ажил мэргэжлээ сурталчлах ажлын хүрээнд Цэнхэр сумын төрийн албан хаагчдад сургалт сурталчилгааг зохион байгуулж, өвөл, зуны бэлчээрийн явуул судалгаанд хамтарч ажиллахаар болов. Мөн “Цаг уурч миний хувь тавилан” уулзалтыг хүчний байгууллагуудын дунд зохион байгуулсан.



Зураг 7. 12-р ангийн сурагчдад, Цэнхэр сумын ЗДТГ, хүчний байгууллагуудад мэргэжлээ сурталчилж буй байдал

Гадаад сургалт:

БНСУ-д 2025 оны 8 дугаар сарын 25-29-нд зохион байгуулагдсан “Installation of integrated weather observation data management system in Mongolia” сургалтанд ерөнхий технологич инженер бөгөөд багаж хэмжил зүй хариуцсан технологич инженер Д.Их-Оюун, төвийн дарга 09 дүгээр сарын 23-28-нд тус тус оролцлоо.

Мэргэжлээ сурталчлан таниулах ажлын хүрээнд сумдын ус, цаг уурын албан хаагчдад энэ арга хэмжээний талаар цахим мэдээлэл өгч, Тариат, Төвшрүүлэх, Эрдэнэмандал, Батцэнгэл, Хайрхан зэрэг сумдын Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдад тухайн сумын ус, цаг уурын өртөө харуулын албан хаагчид сургалтыг зохион байгуулсан байна. Мөн Цахир сумын багш нарт мэдээлэл өглөө.



Зураг 8. Сумдын Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдад сургалт хийж байгаа нь

Бусад сургалтаас дурьдвал:

Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 вебинар сургалт, Zangia.mn-Zangia academy-ын сургалтууд болох ажлын байрны сургалтууд, оффисын цахим хичээлүүд (сертификаттай)-ийг байгууллагын албан хаагчдаар бие даан судлуулах ажлыг зохион байгуулсан.



Зураг.9. ТАЗ-ийн 7:4:10 вебинар сургалт



Зураг.10. Zangia academy-ын цахим сургалтыг судалж сертификат авсан байдал

ХОЁР. ШИНЖИЛГЭЭ СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЛААР

2.1 Ус, цаг уур, орчны шинжилгээний ажлын талаар

Цаг уурын судалгаа, шинжилгээний ажлын талаар

Цаг уурын судалгаа, шинжилгээний ажлыг хөтөлбөрийн дагуу гүйцэтгүүлж мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгууллаа. цаг уурын 4 өртөө, 13 харуулын судалгаа, шинжилгээний цд-1 дэвтэр 48 ширхэг, ЦД-7 дэвтэр ширхэг, ЦД-5 дэвтэр 84 ширхэг, термограф, гигрографийн лент тус бүр 1460 ширхэг, барографийн лент 192 ширхэг, 204 ширхэг цахим тайланг тус тус хүлээн авч техник, шүүмж шалгалт хийж, шалгагдсан цахим тайлан, бичүүрүүдийн туузыг сар бүрийн 20-31-ний дотор Мэдээллий дэд сан (МДС)-д хүлээлгэн өгсөн байна.

Мон-метео програм ашиглан элементүүдийн түүвэр, график, ARCGIS-10.4 тархалтын зураг гарган шүүмжид ашиглаж байна.

Цаг уур, уур амьсгалын салбарын шинжилгээний ажлын дүн урьдчилсан байдлаар ажиглалтын чанар 99.8%, шүүмжийн чанар 99.6%, дундаж дүнгээр 99.2% дүнтэй байна.

Хөдөө аж ахуйн цаг уурын ажлын талаар

Хөдөө аж ахуйн цаг уурын судалгаа шинжилгээний хөтөлбөрийн дагуу гүйцэтгүүлж мэргэжил арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулсан.


Тайлангийн хугацаанд ХД1-24ш, ХД1а-65ш, ХД-76-102 ширхэг дэвтэр, Төвшрүүлэх өртөөний хөрсний чийгийн ажиглалтын ХД-5 7ш дэвтэрт тус тус техник, шүүмж шалгалт хийсэн байна.

Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолын дагуу 2025 оны 8-р сарын 2-р 10 хоногт 19 сумын нутаг дахь хяналт-шинжилгээний 101 цэгт бэлчээрийн төлөв байдлын судалгааг хийж 2025-2026 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг тодорхойлох, холбогдох журам, зааврын дагуу Зудын эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулсан.




Зураг 11. Багийн цэгүүд дээр судалгаа хийж буй байдал

Уг ажлыг хийж гүйцэтгэхэд сум орон нутгийн төсвөөс 3,542,600 төгрөгний шатахуун зарцууллаа. Уг мэдээ, мэдээллийг Архангай цаг уур facebook хаягт байршууллаа.



Зураг 12. Бэлчээрийн даацын мэдээг цахимд мэдээлсэн байдал

Бэлчээрийн даацын мэдээг аймаг, сумын Онцгой комисс болон олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан.



Зураг 13. Зудын урьдчилсан төлөв

Зудын урьдчилсан төлөвийг газрын ажиглалтын болон хиймэл дагуулын мэдээ буюу ган, зуншлага, 2025-2026 оны өвөл-хаврын бэлчээрийн даац, бэлчээрийн ургац, агаарын температур, хур тунадасны дундажтай харьцуулсан хазайлт, цасны бүрхэц, зузаан болон 11 дүгээр сарын агаарын температур, хур тунадасны урьдчилсан төлөв зэрэг мэдээлэлд үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 14-нд нэг сарын урьдчилгаатайгаар тооцоолон гаргалаа.

Хөдөө аж ахуйн цаг уурын салбарын дүн урьдчилсан байдлаар 99.7% дүнтэй байна.

Усны шинжилгээ судалгааны ажлын талаар

Усны шинжилгээ, судалгаа, мэдээлэл үйлчилгээний ажлыг хөтөлбөрийн дагуу гүйцэтгэх, ус судлалын 10 харуулыг мэргэжил арга зүйгээр хангах ажлыг зохион байгууллаа.

Сар бүрийн 05-ны дотор салбаруудын УД-1, УД-2 дэвтрүүд хүлээн авч техник, шүүмж шалгалт хийж, батлагдсан хуваарийн дагуу Гадаргын ус судлалын хэлтэс (ГУСХ)-т УХШ-1 мэдээг сарын 20-нд хүргүүлсэн байна. Усны харуулуудад шалган туслах ажлыг гүйцэтгэж голын хөндлөн зүсэлтийн нивлердлэг хийх, шонгийн засвар, тохируулгыг шалгах, шалгалтын хэмжилтүүд /усны болон агаарын температур/-ийг хийж зааварчилгаа өгсөн байна.




Зураг.14. Гол дээр нивлердлэг хийж, шонгийн засвар, тохируулгыг шалгаж зааварчилсан байдал

2024 оны урсацыг REKI-REJIM програм дээр болон гараар бодож боловсруулан шалгаж 2025 оны 04 дүгээр сарын 01-ний дотор ГУСХ-т цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлсэн байна.

Ус судлалын 10 харуулын өдөр бүрийн усны түвшин 6110 удаа, мөсний үзэгдэл, зузааны 180 удаагийн мэдээг хүлээн авч 10 хоног тутмаар боловсруулан www.tsag-agaar.gov.mn сайтад 36 удаа цахим хэлбэрээр байршуулсан байна.

Хаврын шар усны талаар сэрэмжлүүлэг мэдээгээр ард иргэдэд 1 удаа үйлчилсэн. Үерийн сэрэмжлүүлэг мэдээг 6 дугаар сарын 27-29 -нд, 7-р сарын 02,09,21,22- нд өдрүүдэд тус тус үйлчилсэн.



Зураг.15. байгууллагын вэб сайт болон фэйсбүүк хаягаар мэдээ байршуулсан байдал

Аймгийн ОБГазар болон цахим сайтаар дамжуулсан. Харуулын ажиглагч нар нь ард иргэд, малчид, удирдлага, багийн дарга, ард иргэдэд, сургууль, хүн эмнэлэг тухай бүр мэдээлэл өгөх, мөс цөмрөх, хаврын шар ус, хур борооны үертэй үед, сарын мэдээ, сэрэмжлүүлэг мэдээгээр үйлчлэн ажиллаж байна.

ҮЕР УСНЫ АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЭДЭЭ




28,29-ны өдрүүдэд ихэнх нутгаар дуу цахилгаантай аадар бороо орох тул голын сав, голын эрэг дагуу суурьшиж байгаа аялал жуулчид, малчид иргэдийг үер усны аюулаас онцгойлон анхаарч, бага насны хүүхдэд тавих анхаарлаа дээшлүүлж, голын эргийн дагуу тоглуулахгүй байхыг нийт эцэг, эхчүүд болон асран хамгаалагчдад онцгойлон анхааруулж байна.



АРХАНГАЙ АЙМАГ УЦУОШТӨВ
УС СУДЛАЛЫН САЛБАР
2025.06.27

Зураг 16. ОБГ-ын цахим сайтаар мэдээлсэн байдал

Сумдад өөрсдийн мэдээг цахимд байршуулж үйлчилсэн байна.



Зураг 17. Тариат сумын нуурын ажиглагч, Өлзийт сумын Орхон-Чулуут голын ажиглагч нарын мэдээлсэн байдал

Усны горим, нөөцийн хяналт шинжилгээний ажил 11 дүгээр сарын 30-ны байдлаар 98.5 хувьтай дүгнэгдсэн байна.

Байгаль орчны шинжилгээний ажлын талаар

Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2022 оны 12 сарын 30 өдрийн А/167 тоот тушаалаар MNS/ISO 17025:2018 стандартын шаардлага ханган итгэмжлэгдсэн лаборатори болсон.

2020-2022 онд Байгаль орчны шинжилгээний лаборатори (БОШЛ)-ийг сайжруулах "ТА-9440-MON усны засаглалыг шинэлэг арга замаар хэрэгжүүлэх нь" загвар төсөл хэрэгжиж техникийн шинэчилэл хийгдэж өндөр нарийвчилалтай орчин үеийн багаж төхөөрөмжөөр хангагдсан байна.



Зураг 18. Байгаль орчны шинжилгээний лаборатори

Агаар бохирдуулах эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн ажлыг аймагт зохион байгуулж, дүн мэдээг 2025 оны 03-р сарын 15-нд холбогдох газарт хүргүүлсэн.

Эх үүсвэрийн тооллогын дүнг “Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллогын мэдээллийн сан”-д 04 дүгээр сарын 15-ны дотор шинэчилэн нэгтгэж оруулсан байна.

Агаарын чанарыг 1 цэгт, гадаргын усны чанарыг 11 цэгт, хаягдал бохир усны чанарыг төв цэвэрлэх байгууламжаас хаягдаж буй орох, гарах цэгт тус тус хэмжилт хийж орчны хяналт шинжилгээг тодорхойлох ажлыг хийсэн байна.

Энэ оны 10 дугаар сард Үндэсний итгэмжлэлийн төвд лабораторийн итгэмжлэлийг сунгуулахаар холбогдох баримт бичгийг хүсэлтийн хамт өгсөн бөгөөд Үндэсний итгэмжлэлийн төвийн 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 01/218 албан бичгийн дагуу итгэмжлэлийн бичиг баримтыг тус төвөөс буцаан авч ЦУОШГ-т уламжлан шийдвэрлүүлэхээр 11 дүгээр сарын сарын 22-ны өдрийн 01/180 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Одоогоор шийдвэрлэгдээгүй байна.

БНСУ-ын хөрөнгө оруулалтаар агаарын чанарыг автоматаар хянах станцыг 2025 оны 04 дүгээр сард суурилуулан туршиж, ашиглаж эхэлсэн.

Тус станц нь 24 цаг тасралтгүй агаар дахь бохирдуулах бодис болох азотын давхар ислүүд, хүхэрлэг хий, нарийн ширхэгт тоосонцор/PM2.5/, цаг уурын үзүүлэлтүүд хэмжиж байна.



Зураг 19. Агаарын чанарын автомат станц, хүлээн авч буй байдал

Байгаль орчны шинжилгээний лабораторийн жилийн (11 дүгээр сарын 30-ны байдлаар) урьдчилсан дүн 99.7 хувьтай байна.

Төлөвлөгөөний дагуу баталгаажуулах байсан багаж хэмжих хэрэгслэлээ энэ онд санхүүжилт байхгүйгээс баталгаажуулж чадаагүй.

Цаг уурын автомат станц, багаж, хэмжил зүй, баталгаажуулалтын талаар

2004 оноос техник технологийн шинэчлэлт хийгдэж анхны автомат цаг уурын станцыг суурилуулсан. 2008, 2015 онд Финлянд, 2018, 2023-2024 онд БНСУ-ын цаг уурын автомат станц суурилуулсанаар цаг уурын 17 салбарт автомат станцаар ажиглалт, хэмжилт хийж мэдээ мэдээллээр үйлчилж байна.



Зураг.20. CR1000X -Солонгос автомат

AWS-310 Vaisila

2025 оны баталгаажуулалтын ажлын график, төлөвлөгөөг 01 дүгээр сард батлан мөрдүүлсэн.

Энэ хугацаанд Төвшрүүлэх өртөөнд 4 удаа, Цэцэрлэг өртөөнд 2 удаа, Эрдэнэмандал өртөөнд 2 удаа, Тариат өртөөнд 1 удаа тус тус автомат станцын тоног төхөөрөмжид тус тус тохиргоо үйлчилгээ хийсэн.

ЦУОШГ-т сар бүрийн 10-ны дотор багажийн эвдрэл гэмтэл, хөтөлбөрт ажлын тасалдлын талаар тайлан өгч, шаардлагатай багаж төхөөрөмжийн захиалгыг ЦУОШГ-т хүргүүлж зарим багаж хэрэгслэлээр хангагдсан.

Цаг уурын автомат станцын ээлжит баталгаажуулалтыг очиж 4 өртөө, 13 харуулд хийж тоололтыг боловсруулан БОХЗТЛ-д хүргүүлж гэрчилгээг авсан. Энэ жил баталгаажуулалт 100% хийгдсэн.Орон нутагт томилолтгүй ажиллаа.



Зураг.21. Автомат станцад баталгаажуулалт хийж буй байдал

ЦУОШГ-т сар бүрийн 10-ны дотор багажийн эвдрэл гэмтэл, хөтөлбөрт ажлын тасалдлын талаар тайланг өгсөн.4 өртөө, 13 харуулын цаг уурын автомат станцын газардуулгыг хэмжих ажлыг зохион байгуулсан.

Хэмжилтээр газардуулгын эсэргүүцэл 20-60 Ом буюу Төвшрүүлэх өртөө газардуулгын эсэргүүцэл хамгийн их буюу 60 Ом, Батцэнгэл харуулд багавтар буюу 20 Ом тус тус заасан.



Зураг 22, Газардуулгын хэмжилт хийсэн нь

Ерөнхийдөө газардуулгын эсэргүүцэл 6-8 Ом байхаас их зааж байгаа нь аянга цахилгаанд өртөж тоног төхөөрөмж гэмтэх, шатах эрсдэл их байна. Ялангуяа аянга дуу цахилгаанд их өртдөг Төвшрүүлэх өртөө, Чулуут харуулын шинэ автомат станцад зориулалтын материалаар газардуулга хийх санхүүжилт шаардлагатай байна.

Энэ жил цаг уурын автомат станцуудад конвертор шатах, салхины мэдрүүр гэмтэх зэрэг гэмтлүүд гарсан бөгөөд ихэнх гэмтлийг үйлчилгээ хийж засварласан боловч сэлбэг байхгүй учраас даралт, салхины мэдрүүр засварлагдаагүй байна.

Жилийн эцсийн дүн урьдчилсан байдлаар 99.3 хувьтай байна.

Архив, мэдээллийн дэд сангийн талаар

M_WAMS болон Cliware-2.1 цахим удирдлагын систем, программ хангамжийг архив, мэдээллийн дэд сангийн үйл ажиллагаанд ашиглаж байна.

2025 оны цаасан болон цахим суурьтай баримтуудыг мэдээ мэдээлэл нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөөний дагуу хэлтэс бүрээс хүлээн авч, цаг уурын 4 өртөөний термограф, гигрограф, барограф, өөрөө бичигчүүдийн нийт 2025 оны 3 сарын 15-нд Тариат, Эрдэнэмандал, Төвшрүүлэх, Цэцэрлэг өртөөний агаарын температурын 1464ш, чийгшлийн 1464ш агаарын даралтын 208ш нийт 3136ш тууз хүлээн авч, WAMS-д скайнараж цахимжуулж, данс бүртгэл хөтлөн АМС-н хэлтэст дамжуулав. Цаг уур, уур амьсгалын 48ХН, Ус судлалын 18ХН, Нарны цацраг судлалын 1ХН, ХААЦУ-н 37ХН, ЦАХ-1 хүснэгт 1ХН, Байгаль орчны шинжилгээний лабораторийн 2ХН цаасан баримт хүлээн авч данс бүртгэл хөтлөн EXCEL файл дээр бүртгэсэн бүртгэлийг 2025 оны 05 сарын 15 -нд АМС-н хэлтэст дамжуулав.

Cliware-2.1 системээр 1995-2022 оны бүх салбарын сарын болон хоногийн мэдээнээс шаардлагатай мэдээг боловсруулан авч, салбаруудын isx, tab-аас түүвэр мэдээ авч үйлчилгээндээ тогтмол ашиглаж байгаа бөгөөд 11 дүгээр сарын 27-ны байдлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад нийт 6 удаа (төлбөртэй) үйлчилж 85500 төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

2025 онд архивын зориулалтын 6ш нягтруулсан шүүгээг хаягжуулан, хэсэгчилсэн тооллого явуулж хадгаламжийн нэгжийг ангилан байршуулан өрж архивын өрөөг стандартын шаардлагад нийцүүлж тохижуулан шинжилгээний баримт хадгалах таатай нөхцөлийг бүрдүүлсэн.



Зураг 23. Архивын нягтруулсан шүүгээг хаягжуулсан, ангилсан байдал

11 дүгээр сарын 27-ны байдлаар баримт цахимжуулах төлөвлөгөөний дагуу 2024 оны нийт 3136 ш өөрөө бичигчийн туузыг цахим хэлбэрт шилжүүлэн, 1988-1990 оны Эрдэнэмандал, Тариат, Цэцэрлэг өртөөний ЦД-1 дэвтэрийг цахимжуулан 108 фолдер, 3919 файл 5,84 Gb мэдээг хүлээн авч цахим баримтын удирдлагын систем (M_WAMS)-ийн санд цахимжуулсан баримтын нөөц хувь үүсгэсэн байна.

Энэ оны цаасан суурьтай баримтыг цахим болгох ажлын гүйцэтгэл 100%-ийн биелэлттэй байна.

Мэдээллийн сан, шинжилгээний архивын үйл ажиллагааны жилийн эцсийн дундаж дүн урьдчилсан байдлаар 99.88 хувьтай байна.

Шалган туслах ажлын талаар

Ус, цаг уурын өртөө, харуулд 4 удаа цахимаар зааварчилга арга зүйн зөвлөгөө өглөө. Төвшрүүлэх, Эрдэнэмандал, Тариат Цэцэрлэг өртөөд, Хашаат, Өгийнуур, Батцэнгэл, Хотонт, Хойд-тамир, Өлзийт, Цахир, Чулуут, Хангай, Өндөр-улаан, Урд-тамир харуулд шалган шалган туслахаар ажиллаа.

11 дүгээр сарын 30-ны байдлаар нийт 11 салбарт давхардсан тоогоор 19 удаа шалган туслах ажлыг гүйцэтгэж төлөвлөгөөний биелэлт 100%-тай байна.

2.2 Мэдээлэл үйлчилгээний ажлын талаар


Цаг агаарын хагас хоног, 1 хоног, 5 хоног, 7 хоногийн урьдчилсан мэдээ, сар, улирлын төлөв мэдээг гаргаж цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл болох нөхцөл бүрдсэн үед 48-72 цагийн өмнө малчид, тээвэрчид иргэд, аж ахуйн нэгжид мэдээлж цаг агаарын бодит мэдээ мэдээллээр шуурхай үйлчилэх ажлыг зохион байгуулсан. Үүнд:

Цаг агаарын тойм болон урьдчилсан мэдээ

Цаг агаарын 1 хоногийн тойм мэдээ 365, 7 хоногийн тойм мэдээ 52, сарын тойм мэдээ 12, хагас хоногийн урьдчилсан мэдээ 365, 1 хоногийн урьдчилсан мэдээ 365, 5 хоногийн урьдчилсан мэдээ 365, 10 хоногийн төлөв 104, Хуурайшилтын зэрэг-214, сарын төлөв -12, улирлын төлөв 4 удаа, цаг агаарын нөхцөл бүрдсэн үед анхааруулга-23, сэрэмжлүүлэг-7, гамшигт үзэгдлээс урьдчилан сэрэмжлүүлэх мэдээ 1, нийт бодит болон урьдчилсан мэдээ 1889 мэдээг гаргаж <http://arkhangai.weather.gov.mn/> сайт, Архангай Ус цаг уур, орчны шинжилгээний төв fage хуудас, Архангай цаг уур фэйс хаягт байршуулж байгууллага, иргэдэд үйлчилсэн байна.

Архангай цаг үүр facebook хаяг, “Архангай аймгийн ус цаг уур, орчны шинжилгээний төв” page хуудаст, <http://weather.gov.mn/> сайтад Архангай аймгийн онцгой байдлын газар, Архангай тамир ТВ, АВ ТВ, Масс мессеж, emer.arkhangai@gmail.com, Taikhar@mil.gov.mn, <http://103.111.68.42/mds/login.aspx>, <http://192.168.100.30:3030/login>, <https://arkhangai.weather.gov.mn/admin>,

Аймаг, сумдын facebook. Page хуудасанд байршуулж олон нийтэд хүргэж байна.



Зураг.24. Урьдчилсан мэдээ байршуулсан байдал

Аюул, агаар (ААМО) мэдээний ирц, чанар

Архангай аймгийн нутгаар цаг агаарын тогтворгүй байдал ажиглагдсан үед нийт 17 салбар нэгжээс ирсэн аюул 379, агаар 378 мэдээг серверээс шалгаж дамжуулсан.

Аюул агаар мэдээний ирц 100%, чанар 99.9 байна.

Климат мэдээний ирц, чанар

Цэцэрлэг, Төвшрүүлэх, Эрдэнэмандал, Тариат цаг уурын өртөөний арав хоног, сарын климат мэдээг сар бүрийн 01, 11, 21-нд серверт орсон тухай бүрт хянаж, 10 хоногийн 144, сарын 48 мэдээ дамжуулалтад хяналт тавьж ажилласан. **Чанар 100%.**

Нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчилсэн байдал

Нислэгийн цаг уурын төвтэй <http://amc.namem.gov.mn/>, FTP болон mail хаяг, утсаар мэдээ болон заавар зөвлөмжийг солилцож, сар бүр өмнөх сарын мэдээний таарцыг дүгнэж НЦУТ-д 9 удаа тайлан явуулсан байна.

Төвөөс ирүүлсэн сар бүрийн дүнтэй танилцаж, холбогдох асуудлаар заавар зөвлөмж авч ажилласан бөгөөд хэрэглэгч байгууллагаас гомдол санал ирээгүй байна.

Урьдчилсан мэдээ таараагүйгээс нислэгийн саатал гарсан, хоцроож дамжуулсан, огт дамжуулаагүй мэдээ байхгүй.

Урьдчилан мэдээлэх хэсэг 2025 онд Тойм таф-241, Район-197, Угталт-91 мэдээ гаргаж нийт 107 удаа нислэг үйлдэгдсэн.

Нислэгийн мэдээ зохиолтын чанар 82.4 %, шуурхай үйлчилгээ, шуурхай зохицуулалт 100%, дүн 91.2 хувьтай байна.

Багц мессеж үйлчилгээ

2025 онд багц мессежээр цаг агаарын аюултай үзэгдлийн анхааруулах, сэрэмжлүүлэх мэдээ, гамшигт үзэгдлээс урьдчилан сэрэмжлүүлэх мэдээ нийт 18 удаа, нийт 3132 албан хаагч, иргэдийн гар утасны дугаарт дамжуулсан.(1 удаагийн дамжуулалт 172 албан хаагч, иргэд, нийт зардал 70.000 төгрөг)

Захиалгат болон тусгай хэрэгцээний мэдээ мэдээллээр үйлчилсэн байдал:

Урьдчилан мэдээлэхийн салбараас нийт 27 (ЭБЦТС архангай салбар ТӨХК-д, Төрийн тусгай хамгаалалтын газарт, Ихтамир сумын ерөнхий боловсролын сургуулийн захиргаанд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт, Цагдаагийн газарт-2, "Авто зам засвар арчлалтын нэгтгэл" ТӨХК-ийн Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь салбарт, Авто зам засвар арчлалтын нэгтгэл" ТӨХК-ийн архангай аймаг дахь салбар-2, Саруул харгуй ХХК-д-2, Монгол даатгалд, Мандал даатгалд, Номин даатгалд, Хаан даатгалд-2, Миг даатгалд-2, Онцгой байдлын газарт-3, Уужим цамхаг ХХК-д, Тагнуулын албанд) удаа аж ахуйн нэгж байгууллага, иргэнд цаг агаарын аюултай үзэгдлийн тодорхойлолт гаргаж үйлчиллээ.

Хөтөлбөрт ажлын гүйцэтгэл. Мэдээний таарц, онч, илрүүлсэн хувь

2025 оны жилийн эцсийн дүн урьдчилсан байдлаар 5 хоногийн урьдчилсан мэдээний таарц 90.9% , урьдчилсан мэдээний дундаж таарц 96.4%, АҮ, ГҮ-ээс урьдчилан сэргийлэх мэдээний онч 95.5%, илрүүлэлтийн хувь 100%, дундаж таарц 97.8% ерөнхий дүн 98.2 % байна.

Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлын талаар

Архангай аймгийн УЦУОШТ-ийн дэргэдэх "Цэцэрлэг-Бороо-1" экспедиц нь Цаг уур орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 10-ны А/26 тоот тушаалын дагуу Архангай аймгийн нутаг дэвсгэрт цаг агаарт зориудаар нөлөөлөлж хөрсний чийг, хадлан бэлчээр, үр тарианы ургамлын ургац, гадаргын усны түвшинг тэтгэх, ой хээрийн түймрийг унтраахад дэмжлэг үзүүлэн хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг явууллаа.

2025 онд Төвийн даргын 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр А/33 тушаалын дагуу цаг агаарт зориудаар нөлөөлөх үйлчилгээний технологич инженер Ш.Отгонсамбуу, экспедицийн синоптик инженер С.Мөнхтөр, экспедицийн цаг уурын техникч Ц.Зулзаая, экспедицийн техникч-жолооч Э.Бадрах нар ажил үүргээ гүйцэтгэсэн.

ЦАЗН-д хур тунадас нэмэгдүүлэх экспедицийн технологич инженер Ш.Отгонсамбуу, Экспедицийн техникч-жолооч Э.Бадрах нар "Тэсрэх материалтай харьцах" эрхийн үнэмлэх олгох пиротехникийн хэрэгсэл ашиглах онол, практик, аюулгүй ажиллагааны талаар 04 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд Улаанбаатар хотод сууж, шалгалт өгч, эрхийн үнэмлэхээ авсан.



2025 онд төсвийн хүрээнд байгууллагын бензин, түлшний зардал хасагдан ирсэн тул “Цэцэрлэг бороо-1” экспедиц цаг агаарт зориудаар нөлөөлөх (ЦАЗН) үйл ажиллагааг Сумдын хүсэлтээр нийт 3 удаагийн гаралтаар 5 удаа үйл ажиллагаа явууллаа.



МЭДЭЭЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС 2025 он



2025 оны 05 дугаар сарын 04-ний 08 цагаас 04-ний 20 цаг хүртэлх орсон тунадасны хэмжээ /мм/

№	Сумдын нэр	Тундас/мм/	
		Шөнө/08 цаг/	Өдөр/20 цаг/
1	Эрдэнэбулган	6.0	26.8
2	Тариат	8.0	3.8
3	Эрдэнэмандал	0.0	2.0
4	Төвшрүүлэх	1.0	24.8
5	Батцэнгэл		30.8
6	Булган	6.0	13.8
7	Жаргалант	3.0	12.8
8	Өгийнуур		2.8
9	Өлзийт		
10	Өндөр-Улаан	17.8	4.8
11	Хайрхан		
12	Хангай	3.0	8.8
13	Хашаат		9.8
14	Хотонт	0.0	27.8
15	Цэцэрлэг	1.0	8.8
16	Чулут	0.8	8.8
17	Цахир	8.0	

МЭДЭЭЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС 2025 он

2025 оны 05 дугаар сарын 07-ны 08 цагаас 07-ны 20 цаг хүртэлх орсон тунадасны хэмжээ /мм/

№	Сумдын нэр	Тундас/мм/		Хутацаа цаг/минут	
		Шөнө/08 цаг/	Өдөр/20 цаг/	Шөнө	Өдөр
1	Эрдэнэбулган	8.8	7.8	02.35	10.12
2	Тариат	0.7	2.8	04.25	07.22
3	Эрдэнэмандал	6.0	3.8	04.40	04.10
4	Төвшрүүлэх	0.0	4.8	00.27	06.50
5	Батцэнгэл	0.0	2.8	00.17	05.00
6	Булган	8.8	8.8	00.27	10.40
7	Жаргалант	8.8	2.8	08.04	04.49
8	Өгийнуур	0.0	3.8	00.26	03.10
9	Өлзийт	13.0	2.8	06.33	02.00
10	Өндөр-Улаан	1.8	2.8	01.55	07.51
11	Хайрхан	25.0		07.20	
12	Хангай	0.8	7.8	05.38	08.46
13	Хашаат	2.8	5.8	03.02	05.37
14	Хотонт	0.8	9.8	01.25	10.05
15	Цэцэрлэг	6.0	0.8	08.30	00.25
16	Чулут	1.8		01.12	
17	Цахир	0.8	0.8	04.35	01.08



2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 08 цагаас 07 дугаар сарын 08-ны өдрийн 08 цаг хүртэлх цаг агаарын тойм хүснэгт

№	Сумдын нэр	Тэмц		Т хэрс тэл		Т 08 цаг		Хур тунадас		Цэцэрлэг (мм)		Салхи		Цаг агаарын үзэгдэл	
		Төм	Төм	Төм	Төм	Төм	Төм	нөх	өнх	Өглөн	Өдөр	Шөнө	Өдөр	Шөнө	Я
1	Эрдэнэбулган	26	12	11	15	8.8	3.8			9	8				
2	Тариат	23	10	10	12	4.0				6	5				
3	Эрдэнэмандал	28	13	13	13	4.0				11	9				
4	Төвшрүүлэх	25	12	11	15	4.0				9	6				
5	Батцэнгэл	28	13	15	15	5.0				7	12				
6	Булган	23	10	11	12	0.3	4.0			8	5				
7	Жаргалант	12	12		13	6.0				8	4				
8	Өгийнуур	28	14	14	14	0.5				3	5				
9	Өлзийт	29	16	16	16	0.8				6	4				
10	Өндөр-Улаан	22	11	12	12	4.0				7	4				
11	Хайрхан	29	16	16	16	6.0				9	6				
12	Хангай	20	5	5	12	1.0				10	3				
13	Хашаат	29	16	17	17					5	10				
14	Хотонт	28	14	14	16	0.4				7	9				
15	Цэцэрлэг	24	12	13	12	7.0				5	3				
16	Чулут	22	8	9	12	3.0				8	8				
17	Цахир	20	8	8	10	1.0				5	4				

ТОЙМ БИЧСЭН:
УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭХИЙН ИНЖЕНЕР Б. ЛХАМСҮРЭН



Зураг.25. Цаг агаарт зориудаар нөлөөлж буй байдал

Архангай аймаг дахь “Цэцэрлэг Бороо-1” экспедицийн үйл ажиллагааг идэвхжүүлж Цаг агаарт зориудаар нөлөөлөх арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд шатахуун, томилолтын тооцоо судалгааг гаргаж Аймгийн ЗДТГазарт хүргүүлсэн боловч шийдвэрлээгүй байна.

№	Он, сар, өдөр	Сум	Шатахуун	Томилолт	Пуужин урвалж		G-Mobile	Нийт зардал
			Үнэ2700	Үнэ 30000	Ш	Борооны пуужин үнэ 657638.7 төг	Утасны тооцоо, нэгж	
				/5 хүн/				
1	2025.05.04	Эрдэнэмандал	250,000	300000	3	1972916.1	10000	2,532,916
2	2025.05.06-07	Хайрхан	180,000	300000	4	2630554.8		3,110,555
3	2025.05.07-07	Өлзийт	135,000	300000	2	1315277.4		1,750,277
4	2025.07.08	Эрдэнмандал	250,000	300000	6	3945832.2		4,495,832
Дүн			815000	1200000	15	9864580.5	10000	11,889,581

“Цэцэрлэг Бороо-1” экспедиц нь томилолт, шатахуун, холбоо, борооны пуужин зэрэгт нийт 11,889,581.0 төгрөг зарцуулсан байна.

Архангай аймгийн нутаг дэвсгэрт цаг агаарт зориудаар нөлөөлсөн үйл ажиллагааны үр дүнд 10,195.30 км/кв талбайд 106878 метр/куб ус буюу мөнгөн дүнд шилжүүлбэл 289,854,480.0 төгрөгийн хурын усыг буулгасан байна.

№	Аймаг	ЦАЗНөлөөлсөн Сум	Газар нутгын хэмжээ (км2)	Нэмэгдэж орсон хурын ус (м3)	Нэмэгдэж орсон хурын усны үнэ
1	Архангай	Эрдэнэмандал	3,363.30	24552.09	49104180.0
2	Архангай	Өлзийт	1,720.40	20644.8	41289600.0
3	Архангай	Цэцэрлэг	2,567.30	27726.84	55453680.0
4	Архангай	Хайрхан	2,544.30	72003.69	144007380.0
Нийт дүн			10,195.30	144927.42	289854840.0

“Цэцэрлэг бороо-1” экспедицийн жилийн ажлын гүйцэтгэл урьдчилсан байдлаар 99.3 хувьтай дүгнэгдлээ.

Холбоо, сүлжээ, цахим хуудасны талаар

Байгууллагын холбоо, интернет болон дотоод сүлжээний хэвийн ажиллагааг ханган интернетийн хурдыг speedtest.net программаар өдөр бүр 09 цаг 30 минутад хэмжихэд сүлжээний хурд удааширалтай үед газрын холбогдох мэргэжилтнүүдтэй холбогдож сайжруулах талаар арга хэмжээ авсан ба компьютер сүлжээний тоног төхөөрөмжид хуваарийн дагуу үзлэг үйлчилгээ хийсэн байна.

2025 онд Цэцэрлэг өртөө-1, Төвшрүүлэх өртөө-2, Эрдэнэмандал өртөө-1 цаг уурын өртөөд, Урьдчилан мэдээлэх-2, Уур амьсгалын инженер-1, техникч-2, Нягтлан бодогч-1, Ус судлалын инженер-1, техникч-1, Байгаль орчны шинжилгээний лаборатори-2, Цахир, Булган, Жаргалант, Хашаат, Чулуут цаг уурын харуулуудын 5 компьютерүүдэд (нийт 19) засвар үйлчилгээ хийсэн.

2025 оны 5 дугаар сард Төвшрүүлэх, Цэцэрлэг өртөө, Өгийнуур, Өлзийт харуулуудад автомат станцын харуулуудын газардуулгад хэмжилт хийсэн.


“Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын мэдээллийг байгууллагын цахим хуудас, төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас www.gov.mn, шил ажиллагаа буюу www.shilen.gov.mn-д байршуулах буюу харицсан албан хаагч Хуульд заасан мэдээллийн ангиллыг бүрэн тусгаж, хяналтын жагсаалтаар байршуулж нийтлэх, шинэчлэх, цахим хуудасны хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангаж 1,2,3,4 улирлын мэдээг шинэчлэн тавьсан.

Төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох ep.e-mongolia.mn системийн Албаны цахим шуудан гэсэн хэсэгт байгууллагын албан хаагчдаар албаны мэйл (nar@arkhangai.namem.gov.mn) хаягийг бүртгүүлэх ажлыг зохион байгууллаа.

2025 онд байгууллагын бүх компьютерт вирусн эсрэг лицензтэй Kaspersky программ болох суулгасан.

Эрдэнэмандал, Төвшрүүлэх өртөөнөөс хуучин камеруудыг татан авч байгууллагад хуучин байршлаар нь суурилуулж хэвийн ажиллагаанд орууллаа.

Дээрх 2 өртөөнд шинээр тавигдсан камерууд онлайн горимоор ажиллаж байна.



Зураг 26. Эрдэнэмандал, Төвшрүүлэх өртөөнд шинээр тавьсан камер



Зураг 27. Байгууллагын камер

2025 оны 11 сараас байгууллагын дотоод болон гадаад сүлжээг нэгдсэн журмаар “Юнител” ХХК-иас авах шилэн кабелийг татаж холбон ашиглалтад оруулахад бэлэн болгосон байна.

Холбоо сүлжээний жилийн ажлын гүйцэтгэл урьдчилсан байдлаар 99.94 хувьтай дүгнэгдлээ.


ГУРАВ.ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ТАЛААР

Батлагдсан төсөв, хөрөнгө оруулалтын талаар

Тайлант онд нийт 2,597,855.5 мянган төгрөгний төсөв, 63 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна. 11 дүгээр сарын 30-ны байдлаар 2,193,324.9 мянган төгрөгийн төсвийн гүйцэтгэлтэй байна. 2025 оны өөрийн орлогын төлөвлөгөө 648.0 мянган төгрөг батлагдсан бөгөөд 11 дүгээр сарын гүйцэтгэлээр 737.2 мянган төгрөгийн орлогын гүйцэтгэлтэй байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/20 дугаар захирамжийн дагуу 84,256.1 мянган төгрөгийн санхүүжилт авч аймгийн төвийн сумын албан хаагчдад 20 хувийн орон нутгийн нэмэгдэл цалин олгосон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Төвшрүүлэх сумын Цаг уурын өртөөнд 239,551.7 мянган төгрөг, Эрдэнэмандал сумын Цаг уурын өртөөнд 240,731.4 мянган төгрөгийн тус тус төсөвт өртөгтэй пассив барилга баригдаж, 2025 оны 11 дүгээр сарын 18-19-нд Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг хүлээн авч ашиглалтад оруулсан.



Зураг 28. Цаг уурын өртөөний пассив барилга.Төвшрүүлэх

Нягтлан бодох бүртгэл, тайлагналын талаар

2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2025 оны эхний хагас жил болон 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгэн гаргаж Цаг уур орчны шинжилгээний газарт нэгтгүүлэн, Сангийн яамны Э-тайлангийн нэгтгэлд шивсэн.

Сар бүрийн 02-ны дотор төсвийн гүйцэтгэлийн мэдээг гаргаж аймгийн төрийн сангаар хянуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Цаг уур орчны шинжилгээний газарт сар болгон хугацаанд нь хүргүүлэн байна.

2024 оны 4 дүгээр улирал, 2025 оны 1, 2, 3 дугаар улирлын Ус бохирдуулсны төлбөрийн тайлан, Суутган төлөгчийн хувь хүнд олгосон орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлан, Цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос суутгасан татварын тайлангуудыг хуулийн хугацаанд тайлагнасан.

2024 оны 12, 2025 оны 01-11 дүгээр сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг тайлагнаж нийгмийн даатгалын хэлтсээр баталгаажуулсан.

Нийтийн ил тод байдлын тухай хуулийн дагуу 2025 оны төсвийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн мэдээллийн сангийн <https://shilendans.gov.mn/> сайтад 11 дүгээр сарын 30-ний өдрийн байдлаар мэдээллэх сарын мэдээ 44, тухай бүрийн мэдээ 99, хагас жилийн мэдээ 4, жилийн мэдээ 5 тус тус хуулийн хугацаанд нь бүрэн байршуулж, улирлын тайланг 3 удаа илгээсэн.

Нийтийн ил тод мэдээллийн талаар

Нийтийн ил тод мэдээллийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган arkhangai.namem.gov.mn, shilen.gov.mn сайтуудад холбогдох мэдээллийг тухай бүр байршуулсан.

2025 оны 12 дугаар сарын 03-ны байдлаар нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу 4 дүгээр улирлын тайланг өөрийн байгууллагад хамаарах мэдээллийг байршуулах ажил **75 хувийн явцтай байна.**

ДӨРӨВ.САНАЛ, ДҮГНЭЛТ

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 9 зорилт, 50 арга хэмжээний жилийн эцсийн биелэлт 99.2 хувьтай байна.

Батлагдсан төсвийн хүрээнд Ус, цаг уур, орчны шинжилгээ судалгаа, мэдээлэл үйлчилгээний хөтөлбөрт ажлын хэрэгжилтийг хангаж, 2025 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байна. 10 дугаар сараас эхлэн цалингийн зардлаас бусад зардлын санхүүжилт олгогдохгүй байгаатай холбоотой шуудан холбоо, интернетийн төлбөр, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал гэх мэт зайлшгүй гарсан зардлын хүлээгдэж байгаа өглөг нийт 2,502.7 мянган төгрөг байна. Сар бүр төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах санал хүргүүлж байгаа боловч Сангийн яамнаас хуваарийн өөрчлөлтийг хийхгүй байна. 12 дугаар сарын төсвийн хуваарьт

өөрчлөлт оруулах санал болон үүссэн өрийн талаар газарт холбогдох судалгаа, мэдээг тухай бүр гарган хүргүүлж байгаа бөгөөд 12 дугаар сард Сангийн яамнаас төсвийн хуваарийн өөрчлөлт хийгдвэл жилийн эцсээр өглөггүй ажиллах боломжтой байна.

Цаашид холбооны суваг ашиглалт болон тээвэр шатахууны зардлын төсөвт илүү анхаарч төсвийн төсөлд тусгасны дагуу батлуулах шаардлагатай байна.

Мөн төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төсөв төлөвлөдөг боловч батлагддаггүй, санхүү дутагдалтай байна.

Бүтэц, орон тоо батлахдаа албан тушаал бүрийн нэршил, цалингийн зэрэглэлийг Засгийн газрын тогтоолоор батлагдсан нэршлээр тодорхой болгон баталж өгдөг байх шаардлагатай.

Албан хаагчдын цалин аймаг орон нутаг (аймгийн УЦУОШТ) бүрт харилцан адилгүй тогтоогддог аяагүй ажлын үр дүнд нөлөөлж байна.

Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төсөв санхүүгийн нөөц боломж хомс байна.

Цаашид цаг уурын автомат станцад байнга гарч байгаа техникийн гэмтэл, программын доголдлыг засварлаж, шаардлагатай сэлбэг хэрэгслэлийн нөөцийг бүрдүүлж хэвийн ажиллагааг хангах, ус, цаг уурын шинжилгээ, судалгааны багаж хэрэгслэлийн хангалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.Үүнд:

Цаг уур, орчны шинжилгээний газар болон Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнд дараах саналыг тавьж байна.Үүнд:

- Ус, цаг уур, орчны шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлыг шалган зааварчилах, инженер техникийн ажилтнуудыг холбогдох чиглэлээр танхимын сургалтад хамруулж чадавхжуулах ажлыг зохион байгуулах.

- “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлыг дүгнэх журам”-ын дагуу дүгнэсэн дүнг баталгаажуулж ирүүлж байх (улирал, хагас, бүтэн жилээр), эхний хагас жилийн салбаруудын үнэлгээг жил бүрийн 05 дугаар сарын 30, жилийн эцсийн үнэлгээ 11 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон төвүүдэд баталгаажуулж ирүүлж байх;

- Интернэтийн хурдыг нэмэгдүүлэх, сүлжээ сервер, хамгаалалтын тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлж кибер аюулгүй байдлыг хангах, мэдээллийн технологийн чиглэлээр сургалт явуулах;

Салбарын сайдыг Архангай аймагт ирж байгууллагын үйл ажиллагаатай танилцах үеэр дараах саналыг тавьсан.Үүнд:

1.Төвийн конторын барилгын их засвар өргөтгөл, Тариат өртөөний барилгыг нэгдсэн халаалалтад холбоход нийт 2,823.0 сая төгрөгийг 2026 оны төсөвт батлуулах;

2.Ус, цаг уурын салбарын төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл буюу таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх;

3.Аймаг, сумдын цаг уурын шинжилгээний талбайн ойролцоо барилга, гэр хорооллын газар олгогдож байгаа нь шинжилгээний ажилд нөлөөлөх эрсдэл үүсч Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгад шинжилгээний талбайн газрыг хамгаалах (энэ талаар Газрын тухай хуульд нэмэлт заалт оруулах), мөн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах заалтуудыг тус тус оруулах;

4.ЦУОШГ-ын даргын баталсан 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/11 дугаар тушаалын дагуу албан хаагчдыг хөдөлмөрийн хамгааллын хувцсаар хангах. 18.6 сая төгрөг шаардлагатай;

5.Ус, цаг уурын харуулд 1 ажилтан жилийн 360 хоног тасралтгүй ажилладаг ба өвчтэй чөлөөтэй, ээлжийн амралтаа биеэр эдлэхэд орлон ажиглагч олддоггүй, цалин бага ажиллахгүй байгаа тул цалинг нэмэх төсөв

6.Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд аюулгүй байдлыг хангах зорилгоор нисдэг камер (Дрон)

- 7.БОШЛ-д тоосонцор хэмжих зөөврийн багаж
- 8.Нарны цацраг судлалын автомат станцтай болох
- 9.Автомашинаар хангах гэх мэт.
- 10.Өвлийн цасны судалгаа, зуны бэлчээрийн төлөв байдлын ажиглалтын шатахуун хүрэлцээ муу, ажиглалтыг хийх багаж тоног төхөөрөмж хуучирч шаардлага хангахгүй болсон. 2026 оны ХААЦУ-ын ажиглалт эхлэхээс өмнө өртөө,харуулуудыг багаж хэрэгслээр хангах
- 11.Автомат станцын газардуулгын материал авах төсөв батлах

ТАНИЛЦСАН :

ТАЙЛАН БИЧСЭН:

АРХАНГАЙ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГА

Б.БУЛГАНБААТАР

**Мэдээллийн эх сурвалж: Ерөнхий технологич инженер бөгөөд
багаж хэмжилзүй хариуцсан технологич инженер Д.Их-оюун**

Холбоо барих утас: +97699929119

УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ



Web site:

<https://arkhangai.weather.gov.mn/>

<https://arkhangai.namem.gov.mn/>



Facebook page:

**Архангай аймгийн Ус, цаг уур,
орчны шинжилгээний төв**



Имэйл хаяг:

info@arkhangai.namem.gov.mn



Холбоо барих:

Утас ажил: 70332095

Сүлжээ веб сайт хариуцсан ерөнхий технологич инженер

Холбоо барих утас: +97699558751